



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/354

Булган сум

Гүйцэтгэгчтэй шууд гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XV.1.1.76 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 21 дүгээр зүйлийн 21.1, 34 дүгээр зүйлийн 34.1, дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Хутаг-өндөр сумын төвийн хатуу хучилттай 0,8 км авто замын эхлэлийн ажлын техник технологийн хяналт тавих, зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх “Ар Си Эс Си” ХХК-тай 19,776,436 (арван есөн сая долоон зуун далан зургаан мянга дөрвөн зуун гучин зургаа) төгрөгөөр гэрээ шууд байгуулах эрхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д олгосугай.

2.Гэрээнд заагдсан ажлуудыг холбогдох хууль, журам, норм дүрмийн дагуу тогтоосон хугацаанд чанартай гүйцэтгэж, хүлээлгэн өгөхийг “Ар Си Эс Си” ХХК-ийн захирал (Б.Оюунсүрэн)-д үүрэг болгосугай.

3.Дээрх техник технологийн хяналт тавих, зөвлөх үйлчилгээний ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д, авто зам, замын байгууламжийн барилгын ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж хамтран ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т тус тус даалгасугай.

4.Дээрх ажлын санхүүжилтийг Улсын төсвийн батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ



Засаг Ажил 2024 өдөр бүр Дос/2024/Захирамж

6324010465